

**ВИЗЭЭС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН МАКАОГИЙН ЗАСАГ
ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮСИЙН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар,

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын Төв Засгийн газраас энэхүү хэлэлцээрийг байгуулах бүрэн эрх олгосон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн Засгийн газар,

(цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэнэ),

Хэлэлцэн тохирогч Талуудын найрсаг харилцааг бэхжүүлж, иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх зорилгоор,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

Нэгдүгээр зүйл

1. Хүчин төгөлдөр (дипломат, албан энгийн) үндэсний гадаад паспорт бүхий Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн нутаг дэвсгэрт ер (90) хоногоос хэтрэхгүй хугацаанд визгүйгээр зорчино.

2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн хүчин төгөлдөр паспорт бүхий хүмүүс Монгол Улсын нутаг дэвсгэрт ер (90) хоногоос хэтрэхгүй хугацаанд визгүйгээр зорчино.

Хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан иргэдийг визээс чөлөөлсөнөөр тэдэнд ажиллах эрх олгохгүй. Ажил эрхлэх, мэргэжил дээшлүүлэх, суралцах зорилгоор Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэх, эсвэл 90 хоногоос дээш хугацаагаар зорчих иргэд урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай.

Гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан аль нэг Хэлэлцэн тохирогч Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орж, гарахдаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын гадаад иргэдийн орох, шилжих, оршин суух тухай хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн нөхцөлд олон улсын зорчигчдод нээлттэй хилийн боомтоор нэвтэрнэ.

Дөрөвдүгээр зүйл

Визээс харилцан чөлөөлж буй нь Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт үйлчилж буй хил нэвтрэх, түр болон удаан хугацаагаар оршин суух, ажил эрхлэхтэй холбогдох хууль журмыг хүндэтгэн сахих үүргээс энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлд хамрагдаж байгаа иргэдийг чөлөөлөхгүй.

Тавдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээр нь тааламжгүй гэж үзсэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийг нутаг дэвсгэртээ оруулахаас буюу оршин суулгахаас татгалзах Хэлэлцэн тохирогч аль нэг Талын эрх бүхий байгууллагын бүрэн эрхийг хөндөхгүй.

2. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд энэхүү зүйлийн 1-д дурдсан иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт ямарч үед дахин нэвтрүүлж болно.

Зургадугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд нийгмийн дэг журам, үндэсний аюулгүй байдал, эрүүл мэнд болон бусад хүндэтгэх шалтгаанаар Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно.

2. Эдгээр арга хэмжээг авах болон дуусгавар болгох тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

Долдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан хүчин төгөлдөр зорчих баримт бичгийн загварыг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос 30 хоногийн өмнө Хэлэлцэн тохирогч Талууд дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан зорчих баримт бичгийг өөрчлөх эсвэл энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа шинэ зорчих баримт бичиг хэрэглэх болсон тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа түүний загварыг хэрэглэж эхлэхээс 30 хоногийн өмнө дипломат шугамаар мэдэгдэнэ.

Наймдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг хугацаагүй байгуулав. Хэлэлцэн тохирогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрийг 6 сарын өмнө дипломат шугамаар бичгээр урьдчилан мэдэгдэж цуцалж болно.

Есдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын шаардлагыг гүйцэтгэсэн тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа сүүлчийн мэдээллийг бичгээр өгсөн өдрөөс 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрийг Макао хотноо 2004 оны 7 дугаар сарын 3-ны өдөр монгол, хятад, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад санал зөрвөл англи эх бичвэрийг баримтална.

ОНЦГОЙ БҮСИЙН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

Гарын үсэг

Гарын үсэг